



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2020 оны 01 сарын 30-ны  
сүрлийн 4681 дугаарт бүртгэв.

2020 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 01

Эрдэнэ


Албан татварын хувь  
хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2."д" дахь заалт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэдээс сар тутам авах албан татварын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувиар, хувиараа зорчигч, эсхүл ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа иргэдээс сар тутам авах албан татварын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувиар тус тус тогтоосугай.

2.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д, иргэд олон нийтэд сурталчлах, татварын бааз суурийг нэмэгдүүлж, тэгш хамруулах ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс, аймгийн Татварын хэлтэст тус тус даалгасугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА



0010057